



ОЙРОЛЦОО УТГАТ ӨВӨРМӨЦ ХЭЛЦИЙН УТГА ХЭРЭГЛЭЭНИЙ ОНЦЛОГ

П.Жаргалсайхан
МУБИС-Багшийн сургууль, багш, магистр

Холбоо барих зохиогч: jargalsaikhan.p@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2023.11.11

Хянагдсан: 2023.12.12

Зөвшөөрсөн: 2023.12.25

Хураангуй

Монгол хэл нь дэлхийн бусад хэлнүүдийн адил өвөрмөц хэлцийн баялаг сантай. Өвөрмөц хэлц нь монголчуудын сэтгэхүй сэтгэлгээ аж ахуй, бодот амьдрал, ёс заншил, шашин шүтлэг, үзэл бодол гэх зэргийг нэвт шингээсэн байдаг. Өвөрмөц хэлцийн бүрдүүлбэр дэх үг тус бүрийн цөм утга нь алдагдаж, салгаж болохгүйгээр нэгдэж нэгэн бүхэл өвөрмөц санааг илэрхийлэн хэвшиж, тогтмол хэлэгдэх болсон хоёр болон хэд хэдэн нийлэмж үг юм.

Түлхүүр үг

Хэлц үг, утга, бүтэц, онцлог, хэрэглээ,

Удиртгал

Монгол хэлний өвөрмөц хэлц бол үүсэн бүрэлдсэн, хэвшин тогтсон эх сурвалжаараа эсгий туургатны адуулах мал аж ахуй, хэрэглэх эд агуурс, идэж уух хоол хүнс, өмсөж зүүх хувцас хунар, заншил, монгол хүний сэтгэлгээ, зан суртахуун нүүдлийн соёл иргэншил гэх зэрэгтэй гүн гүнзгий холбоотой юм. Өвөрмөц хэлц нь нэг үг мэт болж утгаараа үл задрах нягт тул зөвхөн гарлын үүднээс үйл явдлын мөрөөр мөшгөн тайлбарлаж болохуйц зүйл байдаг. Түүн дотроо өөр аль ч үндэстэн ойлгоход бэрх, орчуулахад ч хүндрэлтэй төрөл бол яах аргагүй өвөрмөц хэлц үгс билээ. Энэхүү нэг үгийн ард нэлээд утга агуулдаг хэлц үгсийн утгыг бид сайн мэдэж, хэрэглээндээ оновчтой зөв сонгодог байх, хойч үедээ тэр хэвээр нь сурган өвлүүлэн үлдээх нь чухал билээ.

Үндэсний сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таних арга нь чухамдаа юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар, нөхцөл байдлыг эталон¹ тогтсон үнэлэмжээр айлчлан хураангуйлж оюун ухаандаа шингээсэн байдаг учраас түүний хэрэглэх арга хэрэглүүр нь бас л аль болох цомхон хураангуй хэлбэр бүтцийг шаарддаг агаад энэ нь даруй зүйр цэцэн үг, өвөрмөц хэлц гэхчлэн тогтвортой хам бүтэц юм. Хэлний тогтвортой хэллэгүүд нь бүтцийн хувьд хураангуй, дүрслэл нь уран яруу, утга

агуулга нь гүн гүнзгий байдаг. Өөрөөр хэлбэл зүйр цэцэн үг өвөрмөц хэлц нь тухайн хэлээр ярилцагч хүмүүсийн үндэстний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээ, ертөнцийг таньсан амьдралын мэдлэг туршлагынх нь толь буюу зүйрлэн хэлбэл амьдралын тухайн номын зүрх юм. (Баянсан.Ж., 2002.)

Гэвч өнөө цагт залуу хойч үе, тэр дундаа ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, монгол хэлнээс бусад мэргэжилтнүүд аман болон бичгийн хэлний хэрэглээндээ өвөрмөц хэлцийг хэрэглэх нь цөөрсөн бөгөөд энэ нь утгыг нь тэр бүр сайн мэддэггүйтэй холбоотой юм.

Хэрэгцээ шаардлага:

Монгол хэлний өвөрмөц хэлцийн утгыг нарийвчлан судалж, ойролцоо утгаар нь ангилал үүсгэснээр аман болон бичгийн хэл, цаашлаад сонин нийтлэл, уран зохиолын найруулгад оновчтой, өргөн дэлгэр, зөв зохистой сонгон хэрэглэхэд дөхөм болгох ач холбогдолтой. Мөн дийлэнх өвөрмөц хэлцийн тайлбар толь “Хэлц -Тайлбар” гэсэн хэлбэртэйгээр үсгийн дарааллаар болон бүрэлдэхүүнд буй үгсийн хувьд бүлэглэн тайлбарласан байдаг. Жишээлбэл: “гар” гэсэн үг орсон өвөрмөц хэлц нэгжийг утга хамаарахгүйгээр түүвэрлэн оруулсан байдаг. Энэ нь үгийн утгыг тайлахад хэрэглэгдэх ач холбогдолтой ч тухайн тайлбар толийг хэрэглэгч илэрхийлэн хэлэх утгаа мэдэж байгаа ч ямар хэлцээр оноон хэлэхээ олохгүй байх тохиолдолд утгаар нь эрж хайх шаардлага тулгардаг.

Энэ тохиолдолд нэг утгын дор багцлан оруулсан хэлцүүд болон тэрхүү утгатай ойролцоо утгат ямар хэлц нэгжүүд буйг үзэн өөрийн хэлэх гэсэн санаанд тохируулан сонгон хэрэглэх боломжийг бий болгож, цаашлаад баяжуулан хадгалах дамжуулах нэн тэргүүний хэрэгцээ буй билээ.

Үндсэн хэсэг

Монгол хэлний өвөрмөц хэлцийн баялаг сангаас” хүний ажилч хичээнгүй зан араншин, түүний үр дагавар”-тай холбогдолтой 850 гаруй хэлцийг түүвэрлэн ойролцоо утгаар нь ангилан анализ хийлээ. Ажилч хичээнгүйг илэрхийлсэн хэлцийн тухайд юун түрүүнд хөдөлмөр гүйцэтгэдэг чухал эрхтэн болох гар, хуруу, хумсаар төлөөлүүлж толгой, нуруу зэрэг хүний амин чухал эрхтнүүдээр дамжуулан хүний хичээнгүй чанарыг илэрхийлсэн үг хэллэг нилээд байна. Мөн хичээнгүй гэсэн утгыг хүний хамгийн чухал хэрэгцээ болох унтах нойр, идэх хоолоо хойш тавин зүтгэж буйгаар дүрслэн илэрхийлжээ.

Хүснэгт 1. Ажилч хичээнгүй утгат өвөрмөц хэлцийн хэрэглээ

Ажилч хичээнгүй утгат өвөрмөц хэлц			
Бие эрхтэнээ үл хайхрах утгат	Хэрэгцээ хүслээ хязгаарлах утгыг илэрхийлсэн	Амьганаар төлөөлүүлэн илэрхийлсэн	Эдзүйлсээр төлөөлүүлэн илэрхийлсэн
156	125	58	84

Ажилч хичээнгүй утгыг илэрхийлсэн 423 өвөрмөц хэлцийг утга хэрэглээгээр нь судалж үзвэл 37 хувь нь бие эрхтнээ үл хайхрах утгыг гар, хуруу, хумс, нуруу, толгой гэх мэт эрхтнээр төлөөлүүлэн гаргасан бол 29 хувь нь хэрэгцээ хүслээ хязгаарлах утгыг илэрхийлэхдээ нойр, хоол, амь, гэр орон зэргээр төлөөлүүлэн илэрхийлсэн байна. Мөн 20 хувь нь буюу 84 хэлц үгсэд хэрэглэгдсэн эд зүйлсийг ажиглавал хад, чулуу зэрэг хатуу чанга хагарч нугарахад хэцүү чанартай юмс байгаа нь ажилч хичээнгүй төрлийн хүмүүсийг эдгээр зүйлтэй дүйцүүлсэн байна.

Амьтдын хувьд монголчуудын уналага ачлага болон өдөр тутмын амьдралдаа өргөн хэрэглэдэг таван хошуу малын хамгийн ажлын бүтээмж өндөртэй амьтан болох адуу, тэмээг оролцуулсан зэрэг нь хэлц үг бол ард түмний өдөр тутмын амьдралаас урган гарсан гэдгийн нотолгоо болж байна.

Түүнчлэн ажилч хичээнгүй утгат ойролцоо хэлц дэх үйл үгсийг ажиглавал ямар нэг зүйлийг золиосолсон, гарлагдсан, хүнд хүчир утгыг зааж байгаа нь аливаа ажил хөдөлмөрийг амар аргаар хийж гүйцэтгэнэ гэж байдаггүй ажилч хичээнгүй хүнээс ямар хэмжээний тэсвэр тэвчээр шаардагддагийг харж болохоор байна.

Хүснэгт 2. Тэсвэр тэвчээртэй утгыг илэрхийлсэн өвөрмөц хэлц хэрэглээ

Тэсвэр тэвчээртэй утгыг илэрхийлсэн өвөрмөц хэлц			
Өвдөж зовохоо тэвчих утгат	Өлсөж цангахаа тэвчих утгат	Хэцүү бэрхийг тэвчих	Зан авир, ааш зангаа тэвчих утгат
175	84	95	110

Монгол хэлний өвөрмөц хэлцийн баялаг сангаас тэсвэр тэвчээртэй утгыг илэрхийлсэн 460 гаруй хэлц үгийн утга хэрэглээг ажиглавал хүний гадна талд мэдрэгдэхгүй дотоод сэтгэлийн хүчийг илэрхийлсэн үгс элбэг байна. Энэ нь тэвчээрийг зөвхөн биеийн хүч чадал, тамир тэнхээтэй холбох бус сэтгэл санаа чухал үүрэгтэйг харуулж байна. Тийм ч учраас аливаа хүнд хүчир зүйлийг тэвчихийн тулд сэтгэл санаагаа бэлдэх нь чухал гэдгийг илэрхийлсэн утга юм. Судалгаагаар 38 хувь нь өвдөж зовохоо тэвчих (голоо тасартал, нүдээ аньж шүдээ зуух, есөн эрүү давах) утгыг илэрхийлсэн бол 24 хувь нь зан авираа гаргалгүй тэсвэрлэх (биеэ барих, нэг гараараа нөгөө гараа барих) утгат хэлц, хэцүү бэрхийг тэвчих утгат хэлц 20 хувь (гадаа гандаж хөдөө хөхрөх, халуунд халж хүйтэнд хөрөх), өлсөхөө тэвчих утгат хэлц 18 хувь (зодог чангалах, горьлоор гол зогоох) тус тус эзэлж байна.

Судалгааны үр дүн

Монголчуудын аж байдал, соёл, ёс заншил, сэтгэлгээний онцлогийг тодорхой тусгадаг зүйлийн нэг бол өвөрмөц хэлц, зүйр цэцэг үг юм. Иймд өвөрмөц хэлцийн баялаг сангаас “хүний хүний ажилч хичээнгүй зан араншин, түүний үр дагавар”-тай холбогдох 850 гаруй хэлцийг монгол хэл, сэтгэлгээний онцлогоор ажиглан дүгнэлт гаргаснаар аман болон бичгийн хэл цаашлаад аливаа сонин нийтлэл, уран зохиолын найруулгад оновчтой, өргөн дэлгэр зөв зохистой хэрэглэхэд дөхөм болох юм.

Дүгнэлт

Монгол хэлний өвөрмөц хэлцийн баялаг сангаас хүний ажилч хичээнгүй зан чанар болон түүний үр дүн үйл хөдлөлтэй холбогдолтой 860 орчим өвөрмөц хэлц түүвэрлэн судалж үзэхэд 34 хувь буюу 550 орчим хэлц зүйрлэлийн аргаар бүтжээ. Үүнээс үзэхэд монголчууд хүн амьтан, мал аж ахуй, юмсын тухай гүнзгий мэдлэгтэй учраас аливаа нэгэн зүйлийг тэрхүү мэдлэгийн хэрээр сэтгэн бодож хэл сэтгэхүйн салшгүй холбоог баталж ертөнцийн хүн амьтан, юм үзэгдлийг тодотгон зүйрлэх арга ухааныг буй болгожээ.

Түүнчлэн хүний ажилч хичээнгүй чанарыг илэрхийлсэн өвөрмөц хэлц үгсийг түүвэрлэн судалж үзэхэд бие эрхтэнээ үл хайхрах утгат өвөрмөц хэлц, өвдөж зовохоо тэвчих утгат өвөрмөц хэлц үгс нь нилээд хэрэглэгдэж байгаа нь ажиглагдлаа.

Мөн өвөрмөц хэлцийг аман болон бичгийн хэлнээ хэрэглэх нь бага болсон өнөө үед ойролцоо утгаар нь ангилан зааж таниулах нь илүү сонирхолтой төдийгүй утгыг тодруулах зөв оновчтой сонгон хэрэглэхэд дөхөм болох юм.

Ном зүй

1. Ажит. Г.,(1982). Өвөрмөц хэлцийн товч тайлбар толь УБ
2. Бадамдорж. Д., (2017). Танин мэдэхүйн утга зүйн удиртгал УБ
3. Бат-Ирээдүй. Ж., (2009).Монгол хэлний хэлц үгийн сан УБ
4. Баянсан. Ж., (2016).Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ. УБ
5. МУБИС., (2020).Орчин цагийн монгол хэл I, II
6. Цэвэл.Я., (1966). Монгол хэлний товч тайлбар толь

FEATURES OF THE USE OF IDIOMS WITH APPROXIMATE MEANING

Jargalsaikhan.P

Master, Lecturer, Teachers School, MNUE

Corresponding author: jargalsaikhan.p@msue.edu.mn 

Abstract

The Mongolian language, like other language of the word, has a rich fund of unique idioms. The unique idiom permeates Mongolian mentality, thought, life, customs, religion, opinions, etc. The core meaning of each word in the composition of the unique idiom is lost, inseparably combined to express a whole unique idea, and is regularly spoken, are two or more compound words.

Keywords

Idioms, meaning, structure, features and usage
